

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2018 оны 02 сарын 05 -нь өдрийн А /33 тоот захирамж гарч Өсвөрийн шигшээ багийн төрлүүдэд өөрчлөлт оруулж 12 болгон баталсан. Шигшээ багийн тамирчин дасгалжуулагч нараас шинэчилсэн анкетаар дэлгэрэнгүй судалгааг авч бүртгэлжүүлээ.

Өсвөрийн шигшээ багийн төрөлд:

- | | |
|---------------|---|
| 1. Жү-до бөх | 7 . Спортын гимнастик |
| 2. Чөлөөт бөх | 8. Даам |
| 3. Самбо бөх | 9. Байт харваа |
| 4. Бокс | 10. Ширээний теннис |
| 5. Тэшүүр | 11. Волейбол |
| 6. Буудлага | 12. Сагсан бөмбөг гэсэн спортын төрлөөр үйл ажиллагаа явуулж байна. |

2019 оны жилийн эцсийн байдлаар Монголын хүүхдийн спортын наадмын хүрээнд Өсвөрийн шигшээ багт багтсан 12 спортын төрлөөр дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан ба 181 байгууллагын 1980 тамирчин оролцож эхний байр эзэлсэн тамирчид Монголын хүүхдийн спортын 6-р наадмыг шигшээ тэмцээнд оролцох болон хот, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авсан.

Спортын гимнастик, тэшүүрийн шигшээ багийг сэргээлтийн бэлтгэлд хамрууллаа.

Мөн хотын аварга шалгаруулах 5 төрөлд, улсын аварга шалгаруулах 12 төрөлд, тивийн аварга шалгаруулах 3 тэмцээнд оролцоод байна.

Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн тамирчид жилийн эцсийн байдлаар тив, улс, хот, нэрэмжит тэмцээнүүдээс **алт-103, мөнгө-108, хүрэл-139 нийт 350** медаль хүртээд байгаа бөгөөд **11968700** төгрөгийн төсөв зарцуулаад байна.

Үүнээс: дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс **2 мөнгө, 3 хүрэл** , Тивийн аварга шалгаруулах тэмцээнээс **алт-4, мөнгө-3, хүрэл-3 медаль** хүртсэн байна

Монголын хүүхдийн спортын VI наадмаас Өсвөрийн баг тамирчид Алт 21, мөнгө-24, хүрэл 26 медаль хүртэж байгууллагын дүнгээр улсд 3-р байр, нийслэлд 2-р байр эзэллээ.

Дээрх үзүүлэлтүүдээс харахад Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд улс, олон улс, тив, дэлхийн тэмцээнд сайн амжилт үзүүлсэн нь харагдаж байна.

Нийслэлийн дүүргүүдийн өсвөрийн шигшээ багуудын дунд зохион байгуулагддаг уламжлалт тэмцээнүүдэд **Даам, Шатар**, тэмцээнд оролцож **Чөлөөт бөхийн** төрлөөр тэмцээн амжилттай зохион байгууллаа.

2019 онд авсан медалийн тоо

		Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн 2019 оны медалийн тайлан /Жилийн эцэс/																	9-Dec														
№	Дүүргийн өсвөрийн шигшээ багийн төрөл	Тэмцээнд оролцсон тоо						Үзүүлсэн амжилт															Нийт			Санхүүжилт							
		Тамирчдын тоо						Тив дэлхийн тэмцээн			Олон улсын тэмцээн			УАШТ			Улаанбаатар хольц аварга ШТ			Нэрэмжит тэмцээн			Монголын хүүхдийн спортын VI наадам			Нийт	Улсын төсөв	ОН-төсөв	Ивээн тэтгэгч				
		Тив дэлхий	Олон улс	УАШТ	УБ-ХАШТ	Нэрэмжит	Нийт	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл								
1	Жү-до бөх	28	1	2	2	1	2	8	3	2	1	1	3	2	7	7	9	1,1	2	1	5	3	12	11	18	2	1	5	3	98		630000	
2	Самбо бөх	23	1		2		3			1	1				10	3	14	1					6	8	12			5	61		2650000		
3	Чөлөөт бөх	28		1	2		4					1			1	1						5	10	13			2	33		998700			
4	Бокс	13		2			2								1	1									3	2	2	9					
5	Тэшүүр	6			2	1	3	6							2	6			2	2	3	1	3	2	2	3	2	3	21		1800000		
6	Спортын гимнастик	9		1	2		4				1		1	1	2	3	3		2	4	5		1	1	4		2	3	33		1000000		
7	Волейбол	28		1	3	1	2	7				1			1	1	1		2		1		2	4		2		15		2100000			
8	Ширээний теннис	10			2		2																1	1		1		3		1790000			
9	Даам	10	1		2		2	5	1	2	1				8	5	3					18	13	6	1	3	1	2	64		1000000		
10	Сагсан бөмбөг	22			2	1	4												1	1								2					
11	Будлага	7			2		2																					0					
12	Байт харваа	8			2		4								3	1	2					5	7	6		2	1	27					
	Дүн	192	1	1	25	3	14	51	4	5	4	2	5	3	31	24	40		7	6	11		52	57	62	11	11	21	356		11968700		

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НЭРЭМЖИТ НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГҮҮДИЙН ЧӨЛӨӨТ БӨХИЙН ӨСВӨРИЙН ШИГШЭЭ ЭМЭГТЭЙ БАГУУДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн нэрэмжит Нийслэл дүүргүүдийн Чөлөөт бөхийн өсвөрийн шигшээ эмэгтэй багуудын тэмцээн 2019 оны 12-р сарын 08 нд Амгалан цогцолбор сургуулийн зааланд амжилттай явагдаж өндөрлөлөө. Тэмцээнд Багануур, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол, Баянзүрх дүүргийн 1, 2 дугаар өсвөрийн шигшээ баг нийт 6 багийн 92 тамирчин оролцож хурд, хүч авхаалж самбаа сорин өрсөлдснөөс:

1-р байр Д. Гал-Эрдэнэ, Б. Одончимэг дасгалжуулагчтай **Баянзүрх** дүүрэг 92 оноогоор

2-р байр Д. Мөнхбаяр дасгалжуулагчтай **Хан-Уул** дүүрэг 41 оноогоор

3-р байр Ж. Дандар, Н. Пүрэвбаяр дасгалжуулагчтай **Баянгол** дүүрэг 33 оноогоор тус тус байр эзэллээ.





Багуудын өрсөлдөөн ихтэй, цөөн онооны зөрүүгээр байр эзэлсэн үзүүштэй тэмцээн боллоо.

Чөлөөт бөхийн залгамж халаа амжилттай бэлтгэгдэж багш дасгалжуулагч нар үр дүнтэй сайн ажиллаж байгаа нь энэхүү тэмцээнээр харагдаж байна. -Өсвөрийн шигшээ багуудын олон улс тив дэлхийнд оролцож амжилт үзүүлсэн тэмцээнүүдээс дурьдвал.

ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭН

СПОРТЫН ГИМНАСТИКИЙН ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн Спортын гимнастикийн өсвөрийн шигшээ багийн 21-р сургуулийн тамирчид 2018.01.18-21-д ОХУ-ын Благовешенск хотод тэмцээнд амжилттай оролцоод 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртлээ.



Гимнастикийн өсвөрийн шигшээ

багийн тамирчдын ОХУ-ЫН ЛЕНИНСКУЗНЕЦК хотод

Баянзүрх дүүргийн Спортын гимнастикийн өсвөрийн шигшээ баг гимнастикийн сургалттай 21-р сургуулийн баг тамирчид ОХУ-ын “ЛЕНИНСКУЗНЕЦК” хотноо 2019 оны 05 дугаар сарын 26-аас 05 дугаар сарын 29 - ний өдрүүдэд хамтарсан бэлтгэлд, 05 дугаар сарын 30 –аас 06 дугаар сарын 01- ны хооронд “ЛЕНИНСКУЗНЕЦК” хотын захирагчийн нэрэмжит ОУ-ын тэмцээнд амжилттай оролцлоо.

Багийн бүрэлдэхүүнд:

Спортын дэд мастерын зэргээр П.Баасансүрэн ,
Спортын дэд мастерын зэргээр Ц.Хулан,
Спортын дэд мастерын зэргээр Н.Уянга-Ундрах
Спортын дэд мастерын зэргээр Д.Намуунцэцэг
Спортын 1-р зэргээр Г.Анужин
Спортын 2-р зэргээр Ц.Сэрчмаа
Дасгалжуулагчаар Спортын мастер Э.Оргилмаа нар оролцлоо.

Тэмцээнд Монгол, Казакстан, Герман, ОХУ-ын Владивосток, Благовещенск, Чита, Хабаровск, Райчихинск, Сахалин, Белогорск, Комсомольск, Биробиджан нийт 3 орны 18 багийн 120 гаруй тамирчид өсвөр нас, насанд хүрэгчдийн ангиллаар өрсөлдсөнөөс:

Спортын дэд мастерын зэргээр П.Баасансүрэн, Ц.Хулан нар харайлтын төрөлд шигшээ тэмцээнд шалгарч 4-5 байранд оров.

Тус тэмцээнд оролцох замын зардал болон байр хоолны төлбөрийг Баянзүрх дүүргийн биеийн тамир спортын хорооноос гаргаж бидэнд туслалцаа үзүүлсэнд өөрийн зүгээс болон баг тамирчдынхаа өмнөөс талархаж байна.



ТИВ, ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Самбо бөхийн Өсвөр, Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах

Самбо бөхийн өсвөр, залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 10 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Узбекистаны нийслэл Ташкент хотод болж өндөрлөв.

Тус тэмцээнд 43 орны баг тамирчид оролцлоо. Баянзүрх дүүргийн Өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагч Г.Энхбаяр ерөнхий дасгалжуулагчаар оролцсон ба ӨШБ-н тамирчин Амгалан цогцолбор сургуулийн тамирчин О.Хүслэн 48 кг –д хүрэл медаль, залуучуудын ангилалд Г.Энэбиш 62 кг-д мөнгөн медаль хүртлээ. Тус тэмцээнээс Монгол улсын баг тамирчид 2 алт, 3 мөнгө, 6 хүрэл медаль хүртэж Багийн дүнгээр ОХУ-ын багийн дараагаар 2-р байр эзэллээ.



Даамын баг тамирчид

Турк улсын Измир хотод болсон Зуун буудалт даамын залуучуудын ДАШТ Б.Мишээл Хүрэл медаль, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн Алтан медаль, Узбекистан улсын Ташкент хотод зохиогдсон Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний Насанд хүрэгчдийн ангилал үндсэн төрөлд алтан медаль хүртэж Олон улсын их мастерийн болзол хангалаа.

Ц.Цацрал Узбекистан улсын Ташкент хотод зохиогдсон Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний U-11 ангилалд мөнгөн медаль, хүртсэн.

Б.Анужин Турк улсын Измир хотод болсон Зуун буудалт даамын өсвөрийн ДАШТ-д мөнгөн медаль хүртсэн сайхан амжилт гарсан байна.



“Монгол туургатан” тэмцээн

Оросын холбооны улсын Чита мужид болсон “Монгол туургатан” тэмцээнд Волейболын төрөлд Баянзүрх дүүргийн эрэгтэй, эмэгтэй баг тамирчид алтан медаль авсан амжилттай оролцлоо.



БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО